



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

Акт төлүүлэх тухай


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.2 дах хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1.1 дүгээр заалт, 119.2 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын 2021 оны санхүүгийн аудитын шалгалтаар тавигдсан Багахангай дүүрэгт томилолтоор ажилласан ажлын санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг дутуу үйлдсэн 488,000 (Дөрвөн зуун наян найман мянга) төгрөгийн төлбөрийн актыг ажлын хэсгээр, шатахуун зарцуулалтын анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн 145,242 (Зуун дөчин таван мянга хоёр зуун дөчин хоёр) төгрөгийн төлбөрийн актыг Жолооч Ж.Зориггоогоор 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор төлүүлсүгэй.

2. Төлбөрийн актыг төлсөн тухай мэдээ баримтыг 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Г.Ганцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахлах мэргэжилтэн (Н.Пүрэвсүрэн)-д даалгасугай.

ДАРГА



С.БАТЖАРГАЛ